



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/45

Мандалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад  
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Дэлгэрцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш хөгжлийн төвийн ерөөний засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                       |               |                                                                                                        |
|-----------------------|---------------|--------------------------------------------------------------------------------------------------------|
| Комиссын дарга:       | Д.Баатарсүрэн | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)     |
| Нарийн бичгийн дарга: | М.Өлзий       | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)     |
| Гишүүд                | Ж.Уянга       | (Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн) |
|                       | С.Цогбадрах   | (Гүйцэтгэгч "Өнөших трейд" ХХК-ийн даамал)                                                             |
|                       | А.Мөнхбаатар  | (Дэлгэрцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал)                                              |
|                       | Т.Уранбайгаль | (Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга)                                                     |

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Д.Баатарсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЧАГНААДОРЖ

D/ Alban bichig/ Tushaal 2024.09.23

4824010173